

2-р бүлэг. Хот, дүүрэг, орон нутгийн бүртгэлүүд

1. Шаардлагатай бүртгэлүүд

1.1 Хаягийн бүртгэл

Гадаад иргэдээс дараах хүн нь хот, дүүрэг, орон нутгийн захиргаанд хаягийн бүртгэл хийлгэх шаардлагатай.

Бүртгэл хийх шаардлагатай хүн

- Оршин суух үнэмлэхтэй хүн (Дунд, урт хугацааны оршин суугч)
- Тусгай байнгын оршин суугч
- Түр хамгаалалтын зөвшөөрөлтэй болон түр оршин суух зөвшөөрөлтэй хүн
- Шинээр төрсөн хүүхэд, эсвэл Япон улсын иргэншлээс гарсны дараах хугацаанд оршин суух хүн

Шинээр газардах зөвшөөрөл авч Япон улсын хилээр нэвтэрсэн тохиолдолд Хаяг тодорхой болсон өдрөөс 14 хоногийн дотор хот, дүүрэг, орон нутгийн захиргаандаа шилжин ирж буй бүртгэл хийлгэх шаардлагатай.

Өргөдөл гаргах үедээ оршин суугчийн үнэмлэх (сүүлд авах хүмүүс паспорт)-ээ авч очно уу.

- Гэр бүлтэйгээ хамт амьдрах тохиолдолд, гэрлэлтийн баталгаа болон төрсний гэрчилгээ зэрэг гэр бүлийн холбоо хамаарлыг батлах албан бичиг шаардлагатай.
 - Шилжин ирж буй бүртгэл дараах дарааллын дагуу явагдана.
 - ① Шилжин ирж буй бүртгэл хийлгэхэд оршин суугчийн үнэмлэх дээр бүртгүүлэх хаяг нэгэн зэрэг бүртгэгдэн тэмдэглэгддэг.
 - ② Оршин суугчийн бүртгэл хийгддэг.
 - Овог нэр, төрсөн огноо, хүйс, хаяг зэрэг бичигдэнэ.
 - Амьдарч байгаа нөхцөл зэргийг нотлохын тулд, оршин суугчийн бүртгэлийн хуулбар авах боломж нээгддэг. (Төлбөртэй)
 - ③ Хот, дүүрэг, орон нутгийн захиргаанаас танд хувийн дугаар (my number) мэдэгдэнэ.
- ※ My number: Япон дахь нийгмийн хамгаалал, татвар, осол гамшгийн хамааралтай бүртгэл хийх үед таныг шууд тогтоох зорилготой 12 оронтой дугаар юм.
- Дэлгэрэнгүйг 2 Хувийн дугаарын (my number) тогтолцоо хэсгээс үзнэ үү.
 - ④ Хувийн дугаарын үнэмлэхний өргөдөл гаргаагүй хүнд шуудангаар хувийн дугаарын мэдэгдэлтэй хамт үнэмлэх авах өргөдлийн маягт хавсарган ирэх тул үүнийг ашиглан өргөдөл гаргана уу.

